



МУИС-ИЙН БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ДЭЭД КУРС

МЕНЕЖМЕНТИЙН АХИСАН ТҮВШНИЙ ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН ТОВЧ ТОЙМ

Байнгын хөгжил, өөрчлөлттэй бизнесийн орчинд ажиллагч менежер, удирдах ажилтан, энтрепренёр хүн өөрийгөө тогтмол хөгжүүлж байх нь ажил хэргийн чухал шаардлага байдаг билээ. Тэгвэл та өөрийгөө хөгжүүлж чадаж байна уу? Ажил хэргийн ачааллаас шалтгаалан мэдлэг, ур чадвараа хөгжүүлж, «номын дуу сонсож» амжихгүй явсан бол одоо цаг нь болжээ. Монгол улсад шилдэг бизнесийн удирдагчдыг сурган бэлдэж ирсэн МУИС-ийн Бизнесийн сургууль (хуучнаар Эдийн засгийн сургууль) Бизнесийн удирдлагын дээд курс: Менежментийн ахисан түвшний хөтөлбөрийг танд санал болгож байна. Тус сургалтанд суралцсанаар та орчин үеийн менежментэд гарч буй сүүлийн үеийн мэдлэг, арга барилуудыг богино хугацаанд суралцаж, ажилдаа хэрэгжүүлэх чухал санаануудыг олж авна.

СУРГАЛТАНД ХЭН ХАМРАГДАХ ВЭ

Аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдах ажилтнууд, алба, хэлтсийн дарга, бие даасан бизнес эрхлэгчид.

СУРАЛЦАГСДЫН СУРЧ МЭДЭХ ЗҮЙЛС

- Тодорхойгүй байдалд стратегийн нарийвчилсан шинжилгээ хийж, компанийнхаа чиглэлийг оновчтой сонгох, өрсөлдөөний давуу тал бий болгох, өсөлтийн стратеги хэрэгжүүлэх мэдлэгтэй болно
- Компанидаа тохирох бизнесийн оновчтой загварыг тодорхойлж, хэрэгжүүлэх мэдлэг олж авна.
- Зах зээл бий болгох, оновчтой сегментийг сонгох, тохирох үнэ цэнийг бүтээх мэдлэгтэй болно.
- Орчин үеийн мэдээллийн технологийн ололт, их хэмжээний өгөгдлийн шинжилгээ хийж өрсөлдөөний давуу тал олох үндсүүдийг ойлгоно.
- Макро эдийн засгийн гол үзүүлэлтийн нөлөөллийг бизнестээ тооцох, эдийн засгийн өсөлт, боломжийг ашиглах чадвартай болно.
- Компанийн хөрөнгө оруулалтын зөв багц бүрдүүлэх, өндөр үр өгөөжтэй, тогтвортой бизнес эрхлэх зарчмуудыг сурна.
- Бизнес, компанийн хөгжлийн үе шатууд, тэдгээрт хэрэгжүүлэх стратегиудыг мэдэж авна.
- Аж ахуйн нэгжийн татварын удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, болзошгүй эрсдэлүүдээс зайлсхийх арга замуудыг сурна.
- Манлайлах чадвараа оношилж, хөгжүүлэх арга замуудыг таньж, нөхцөл байдалд тохируулан ажилтнуудыг удирдах арга барил олж авна.
- Байгууллага дахь эерэг өөрчлөлтийг амжилттай удирдах зарчмуудыг сурна.
- Үйл ажиллагааны оновчтой стратеги сонгож хэрэгжүүлэх, нийлэлтийн сүлжээг үр нөлөөтэй удирдах, инновацийн менежмент хийх арга барилд суралцана.

СУРГАЛТЫН ҮНДСЭН МОДУЛИУД

Сургалт нь Стратеги ба маркетинг, Эдийн засаг, санхүү, Хувь хүний болон байгууллага дахь манлайлал, Үйл ажиллагааны менежмент гэсэн үндсэн 4 модуль, тэдгээрийн хүрээнд заагдах хичээлүүдээс бүрдэнэ.

СТРАТЕГИ БА МАРКЕТИНГ

- Стратегийн менежмент
- Бизнесийн загвар
- Маркетингийн стратеги
- Бизнес аналитик

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ

- Монголын эдийн засгийн өнөөгийн байдал, хөгжлийн хандлага
- Хөрөнгө оруулалтын багцын удирдлага
- Санхүүгийн стратеги
- Аж ахуйн нэгж, байгууллагын татварын удирдлага

СУРГАЛТЫН ХУГАЦАА БОЛОН ТӨЛБӨР

Сургалт үргэлжлэх хугацаа:
25 хоног /2014.05.26-06.19/
Сургалт явагдах өдрүүд:
Долоо хоног бүрийн Даваа-
Пүрэв гаригийн 18:00-21:00
цаг
Төлбөр: 1 хүн – 595.000
төгрөг
Бүртгэл: 2014 оны 5 сарын
23-ныг хүртэл бүртгэнэ.

ХОЛБОО БАРИХ

Г. Нарангэрэл
Утас: 99227130
Цахим шуудан:
naagii0116@yahoo.com
Цахим хуудас:
www.bs.num.edu.mn

Бизнес Консалтинг Төв
МУИС-ийн Бизнесийн
сургууль



МУИС-ИЙН БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ДЭЭД КУРС

МЕНЕЖМЕНТИЙН АХИСАН ТҮВШНИЙ ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН ХУГАЦАА БОЛОН ТӨЛБӨР

Сургалт үргэлжлэх хугацаа:
25 хоног /2014.05.26-06.19/
Сургалт явагдах өдрүүд:
Долоо хоног бүрийн Даваа-
Пүрэв гаригийн 18:00-21:00
цаг
Төлбөр: 1 хүн – 595.000
төгрөг
Бүртгэл: 2014 оны 5 сарын
23-ныг хүртэл бүртгэнэ.

ХОЛБОО БАРИХ

Г. Нарангэрэл
Утас: 99227130
Цахим шуудан:
naagii0116@yahoo.com
Цахим хуудас:
www.bs.num.edu.mn

Бизнес Консалтинг Төв
МУИС-ийн Бизнесийн
сургууль

ХУВЬ ХҮНИЙ БОЛОН БАЙГУУЛЛАГА ДАХЬ МАНЛАЙЛАЛ

- Манлайллын үндсүүд
- Манлайлах чадвараа үнэлж, хөгжүүлэх нь
- Амжилттай хэлэлцээр хийх арга барил
- Өөрчлөлтийг удирдах нь

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ

- Үйл ажиллагааны стратеги
- Олон улсын худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээний менежмент
- Инноваци

ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ СУРГАГЧ БАГШ

Ш. Алтанбагана

«Терра Экспресс» ХХК-ийн Захирал

М. Халиунбат

«ҮМС» ХХК-ийн Захирал

Б. Болд

«Юнител Групп» ХХК-ийн Тэргүүн дэд захирал

А. Ганхуяг

МСиЭс Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Ч. Алтаннар

Доктор, санхүүгийн профессор, МУИС-ийн Бизнесийн сургууль

Б. Эрдэнэбат

Доктор, санхүүгийн профессор, МУИС-ийн Бизнесийн сургууль

Ц. Сайнбуян

Баянзүрх Дүүргийн Татварын Хэлтсийн Дарга

Ш. Батжаргал

«В+» ХХК-ийн Захирал

Г. Цэрэн

Доктор, Менежментийн дэд профессор, МУИС-ийн Бизнесийн сургууль

Д. Батсайхан

Төрийн Банкны Гүйцэтгэх захирал

Л. Соронзонболд

Худалдаа Хөгжлийн Банкны Тэргүүн дэд захирал

Н. Батнасан

Доктор, Олон улсын худалдааны профессор, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Захирал

Н. Сонинтамир

Доктор, Менежментийн профессор, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Дэд захирал

Г. Үүрдмандах

Докторант, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Бизнес Консалтинг Төвийн Менежер

МУИС-ийн ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛЬ ТӨГСӨГЧИЙН ХОЛБОО



“Бизнесийн удирдлагын дээд курс”
2013.04.26

“БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ДЭЭД КУРС” II ТӨГСӨЛТ



МУИС-ийн ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛЬ ТӨГСӨГЧИЙН ХОЛБОО
2013.11.28